



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/122/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Батжаргал

Утас: 70584207 Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14



2.1. Оршил

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Аюушмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын эрхэм зорилго нь “Аймгийн мал сүргийг эрүүлжүүлэх, худалдааны чөлөөт байдлыг дэмжих, хүнсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах”-д оршино.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаа
- Урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх
- Сургалт, сурталчилгаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Dynamic программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны

жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 4,470,892.1 мянган төгрөгөөс тооцон 89,417.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 82,010.2 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант үеийн элэгдлийн зардлыг буруу тооцсонтой холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар 2019 онд шинээр байгуулагдсан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	0	530,121.7	0
Үндсэн хөрөнгө	0	1,701,125.8	0
Хуримтлагдсан элэгдэл	0	-817,491.0	0
Нийт хөрөнгө	0.0	1,413,756.5	0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0	1,413,756.5	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0.0	1,413,756.5	0

Бараа материал, үндсэн хөрөнгө аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас балансаас балансад шилжүүлэн авсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар нь 2019 онд 1,500.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөж, гүйцэтгэлээр 1,422.0 мянган төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 564,901.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Нийт зардлын 564,901.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: орон нутгийн төсвөөс 231,948.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,276,505.0 мянган төгрөг нийт 1,508,453.2 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,504,435.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,017.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 520,210.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 24,874.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 490.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж, 494,801.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд залруулга хийлгэлээ.

Аудитаар 25,365.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 24,874.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Бараа материалын худалдан авалтын 32.2 хувь буюу 24,874.5 мянган төгрөгийн анхан шатны баримтад е-баримтыг хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 490,7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийх нийцлийн аудитаар шалгана.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд шинээр байгуулагдсан байгууллага учир өмнөх зөвлөмжийн биелэлт гаргахгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Цалин, хөлсний талаар

1.1. **Илрүүлэлт**: Цалин, хөлснөөс суутгаж авсан сахилгын шийтгэлийн нийт 490.7 мянган төгрөгийг аймгийн Татварын хэлтэст, хүү торгуулийн орлогод төвлөрүүлээгүй.

1.2. **Эрсдэл**: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. **Өгсөн зөвлөмж**: Сахилгын шийтгэлийн суутгалыг татварт шилжүүлж байх.

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар**: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	530121697.64
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	530121697.64
351	Түүхий эд материал	0.00	512608357.44
35110	Тусгай зориулалттай материал	0.00	173621105.12
35130	Эм боох материал	0.00	338987252.32
354	Хангамжийн материал	0.00	17063340.20
35410	Бичиг хэргийн материал	0.00	560000.00
35420	Аж ахуйн материал	0.00	16203118.20
35470	Бусад хангамжийн материал	0.00	300222.00
35600	Мал амьтад	0.00	450000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	883634772.14
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	883634772.14
392	Биет хөрөнгө	0.00	752611772.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	569256054.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-22551250.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	230012123.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-180096201.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	740776627.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-607913945.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.00	29901049.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-6772684.72
393	Биет бус хөрөнгө	0.00	131022999.97
39301	Программ хангамж	0.00	1180000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-157000.03
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	130000000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	1413756469.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	1413756469.78
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	1413756469.78
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	933633069.49
51200	Хуримтлагдсан үр дүн		1265812547.09
51210	Өмнөх үеийн үр дүн		-480123400.29
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	1413756469.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		480123400.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	1413756469.78

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	5959766398.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	3886411520.23
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	3886411520.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1389000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1389000.00
120009	Бусад орлого	0.00	219000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		972571571.08
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа ммтериал		2912231949.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	2073354878.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	564901700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	564901700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1508453178.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	231948176.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1274566990.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1938012.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	4546009928.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	4546009928.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	4537501367.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	358645850.24
210101	Үндсэн цалин	0.00	358645850.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	48352623.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	30499322.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	3588156.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	6371200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	717632.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	7176313.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	12233915.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	3574700.00
210302	Түлш, халаалт	0.00	7679500.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	979715.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	79214350.28
210401	Бичиг хэрэг	0.00	6202821.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	22355632.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	2200262.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	7760382.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	40695252.31
2105	Нормативт зардал	0.00	2369132400.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	2369025420.20
210502	Хоол, хүнс	0.00	106980.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	1641800.00
210604	Урсгал засвар	0.00	1641800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1504531422.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1503618422.76
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	215000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	198000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	163749005.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	11470606.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	152278399.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8508561.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	3500000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	3500000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	5008561.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5008561.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	1413756469.78
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	1413756469.78

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	2074995878.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1641000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1641000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1422000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	1422000.00
120009	Бусад орлого	0.00	219000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	2073354878.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	564901700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	564901700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1508453178.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	231948176.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1276505002.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	2011654277.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	2011654277.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	2003145715.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	68624100.00
210101	Үндсэн цалин	0.00	54877000.00

210102	Нэмэгдэл	0.00	10083700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3663400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	8578200.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	5833100.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	686300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	549100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	137200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	1372500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	12233915.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	3574700.00
210302	Түлш, халаалт	0.00	7679500.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	979715.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	25298112.97
210401	Бичиг хэрэг	0.00	5106100.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	13591870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	6600142.97
2105	Нормативт зардал	0.00	8836100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	8100500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	735600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	12153500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1285200.00
210604	Урсгал засвар	0.00	10868300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	1866543088.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1865630088.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	215000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	198000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	878700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	878700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8508561.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	3500000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	3500000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	5008561.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	5008561.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	63341601.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	63341601.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	63341601.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	63341601.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	63341601.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-63341601.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-480,123,400.29	-480,123,400.29
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	-480,123,400.29	-480,123,400.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	480,123,400.29	0.00	480,123,400.29
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	1,413,756,469.78	1,413,756,469.78
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	480,123,400.29	933,633,069.49	1,413,756,469.78

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	566401700.00	565552028.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	566401700.00	565552028.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	562901700.00	562052028.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	68624100.00	68624100.00
210101	Үндсэн цалин	54877000.00	54877000.00
210102	Нэмэгдэл	10083700.00	10083700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3663400.00	3663400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8578200.00	8578200.00
210201	Тэтгэврийн даатгал	5833100.00	5833100.00

210202	Тэтгэмжийн даатгал	686300.00	686300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	549100.00	549100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	137200.00	137200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1372500.00	1372500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12235000.00	12233915.00
210301	Гэрэл, цахилгаан	3574700.00	3574700.00
210302	Түлш, халаалт	7679500.00	7679500.00
210303	Цэвэр, бохир ус	980800.00	979715.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25299700.00	25298112.97
210401	Бичиг хэрэг	5106100.00	5106100.00
210402	Тээвэр, шатахуун	13699700.00	13591870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6493900.00	6600142.97
2105	Нормативт зардал	8836100.00	8836100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8100500.00	8100500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735600.00	735600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74315500.00	74315101.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23640200.00	23640200.00
210604	Урсгал засвар	50675300.00	50674901.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	364134400.00	363287800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	362374800.00	362374800.00
210803	Даатгалын үйлчилгээ	500000.00	500000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215000.00	215000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	204600.00	198000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	878700.00	878700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	878700.00	878700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3500000.00	3500000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3500000.00	3500000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3500000.00	3500000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	564901700.00	563911028.97
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	564901700.00	563911028.97
122005	Орон нутгийн төсвөөс	564901700.00	563911028.97
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	1500000.00	1422000.00